МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

ADB

JFPR Japan Fund for Prosperous and Resilient Asia and the Pacific

From the People of Japan

Mongolian Education Alliance — Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

# ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ

## Оролцогч талуудын чадавх бэхжүүлэх сургалтын модуль



- БШУГ, БОЛОВСРОЛЫН ХЭЛТЭС
- САЛБАР КОМИСС
- БОЛОВРОЛД ХАМРАГДАЛТЫГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛ
- ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ДЭМЖЛЭГИЙН БАГ

Улаанбаатар хот

2022 он

*Тус модулийг **“Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”**-ийн хүрээнд боловсруулав.*

*БОЛОВСРУУЛСАН:*

*Б.Болорчимэг (Төслийн зөвлөх багийн ахлагч, магистр)*
*Ч.Жаргал (Докторант)*
*Д.Гэрэл (Магистр)*

*ЭХ БЭЛТГЭСЭН:*
*Б.Батбаяр*

*ХЯНАСАН:*
*Б.Батжаргал (Төслийн жендерийн зөвлөх)*

*“Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”-ийн зөвшөөрөлгүй хувилж, дахин хэвлэхийг хориглоно.*

# ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Боловсрол, шинжлэх ухааны яам нь Азийн Хөгжлийн Банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн 2 сая ам.долларын буцалтгүй тусламжаар “Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”-ийг 2021-2024 онд хэрэгжүүлж байна. Уг төслөөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахыг зорьж буй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхлаас ангид нийгмийн бүх харилцаанд тэгш оролцох нь төслөөс хүлээгдэж буй үр нөлөө юм. Уг төсөл нь дараах 3 бүрэлдэхүүн хэсэгтэй:

**Үр дүн 1:** Ердийн цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг сайжруулах
**Үр дүн 2:** Тэгш хамран сургах боловсролын үйлчилгээг хүргэх чадавхыг бэхжүүлэх
**Үр дүн 3:** Тэгш хамран сургах боловсролыг дэмжих нөөц боломж, олон нийтийн оролцоо болон бодлогыг сайжруулах.

**Төслийн зорилтот орон нутаг, сургалтын байгууллага:**

- Дархан-Уул аймгийн 12 дугаар сургууль, 7 дугаар цэцэрлэг
- Дорнод аймгийн 1 дүгээр сургууль, 8 дугаар цэцэрлэг
- Дундговь аймгийн “Говийн ирээдүй” цогцолбор сургууль, 3 дугаар цэцэрлэг
- Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар сургууль, 253 дугаар цэцэрлэг

Энэхүү сургалтын модулийг “Тэгш хамран сургах боловсролыг дэмжих нөөц боломж, олон нийтийн оролцоо болон бодлогыг сайжруулах” Үр дүн 3-ын хүрээнд боловсруулав.



## НЭГ: МОДУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**Зорилго:**
Тэгш хамран сургах боловсролын үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, бүтээлчээр хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

**Хүрэх үр дүн:**

- Тэгш хамран сургах боловсролын талаарх орчин үеийн үзэл хандлага, зарчмын талаарх ойлголтоо өргөжүүлнэ.
- Хүүхдийн хөгжлийн цогц дэмжлэгийн тогтолцоо, түүнд оролцогч талуудын үүрэгтэй танилцаж, хамтран үр дүнтэй ажиллах чадварт суралцана.
- Дэмжлэгийн багийн үндсэн үүргийг ойлгож, гишүүдийн арга зүйн чадавх бэхэжнэ.
- Дэмжлэг шаардлагатай хүүхдэд боловсрол, нийгэмшихүйн үйлчилгээг үзүүлэх цэцэрлэг, сургуулийн удирдлага, зохион байгуулалт сайжирна.

**Сургалтын цаг:** 2 өдөр/16 цаг

**Товч агуулга:**

Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих суурь үнэт зүйлс, ур чадварын талаар багш нарт дэмжлэг үзүүлэх, олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах нь нэн чухал билээ.

Бухий л суралцагчдыг сургуулийн өмнөх боловсролоос авахуулаад бүх шатны боловсролын үйлчилгээнд хамрагдаж, үр дүнтэй, тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэхэд орон нутаг, сургалтын байгууллага, оролцогч талуудын тэгш хамран сургах боловсролын талаарх арга зүйн чадварыг нэмэгдүүлэхэд энэхүү сургалтын модуль хувь нэмрээ оруулах юм. Модулиар цэцэрлэг, сургууль дээрх “Дэмжлэгийн баг”-ийн эрх зүйн орчин, үйл ажиллагааны үндсэн үүрэг, түүнийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн төлөвлөгөө, арга зүйн хувилбар, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах аргачлалыг жишээ кейст тулгуурлан хүргэхийг зорилоо.

Энэхүү сургалтын модулийг Боловсрол шинжлэх ухааны газар, Боловсролын хэлтсийн мэргэжилтнүүд, Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, Дэмжлэгийн багийн гишүүдээс гадна эцэг эх, олон нийт, оюутан сурагчид танхим, онлайн, зайн хэлбэрээр судлах боломжтой.



## Тэгш хамран сургах боловсрол

Бүхий л суралцагчдад хүрч үйлчлэх боловсролын тогтолцооны чадварыг бэхжүүлэх үйл явц. Тэгш хамран сургах боловсрол нь бүх хүний хувьд хоёр талын үнэ цэн, хүндлэлийг урамшуулдаг.

***Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлан 2020***

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн цогц дэмжлэгийн тогтолцоо

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэгийг үзүүлэх тогтолцоо нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх
- Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг төлөвлөж, шийдвэрлэх
- Хөгжлийн дэмжлэг, оролцоо, үйлчилгээнд хамруулах.

## Салбар комиссын үүрэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлийн эрэлт хэрэгцээг судалж, хүүхдийг бүх талаас нь судлан цогц үнэлгээ хийнэ. Өөрөөр хэлбэл, хүүхдийн амьдарч буй орчны бүхий л асуудал, хүүхэд, эцэг эхийн хүсэл эрмэлзэл, давуу талуудыг цогц байдлаар авч үзнэ.

## Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл

Аймаг, дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах үүрэг бүхий “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийг тухайн шатны Засаг даргын тушаалаар байгуулна.

## Дэмжлэгийн баг

Цэцэрлэг, сургууль нь хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус 7-9 хүний бүрэлдэхүүнтэй “Дэмжлэгийн баг”-ийг байгуулж ажиллана.

## Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)

Зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүй, хөдөлгөөний хөгжил нь үе тэнгийн хүүхдүүдтэй харьцуулахад харьцангуй удаан байх тохиолдол байдаг учраас тэдэнтэй нэг ижил арга зүйгээр суралцах, анги, хамт олноороо хийх үйл ажиллагаанд оролцоход бэрхшээл учирдаг. Энэхүү шалтгааны улмаас ГСТ боловсруулж, хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн арга зүй, дэмжлэг үзүүлж, тухайн хүүхдийг хөгжүүлэх бодит боломж бүрдүүлнэ.



**Хэрэглэгдэхүүн :**

- Уншиж судлах материал (PDF)
- Power point танилцуулга (PP.T)
- Ажлын хуудас
- Дадлага ажлын удирдамж
- Өөрийн үнэлгээний сорил даалгавар
- Нэлттэй цахим холбоос
- Ном, гарын авлагын жагсаалт
- Үнэлгээний рубрик
- Видео

**Үнэлгээ:**

Оролцогч талуудын чадавх бэхжүүлэх сургалтын модулийн үнэлгээг танхимд дадлага ажлын, онлайн болон зайн орчинд бие даан гүйцэтгэх даалгаврын гүйцэтгэлээр үнэлнэ.

| Үнэлгээний давтамж | Гүйцэтгэлийн үнэлгээ | Үнэлгээний эзлэх хувь | Тайлбар |
|---|---|---|---|
| Явцын үнэлгээ | 30 хүртэл оноо | 30% | Дэд сэдэв тус бүрийн агуулгын хүрээнд оролцоо, идэвх, гүйцэтгэлээр нь багаар үнэлнэ. |
| Эцсийн үнэлгээ | 70 хүртэл оноо | 70% | Сургагч багшийн зөвлөмжийн дагуу сайжруулсан, турших хэрэгжүүлсэн үр дүнг рубрикийн аргаар үнэлнэ. |
| Нийт оноо | 100 | 100% | |

**Гарааны үнэлгээ: Өөрийн үнэлгээний хуудас**

*Зорилго: Сургалтын байгууллага, багш, ажилтны тэгш хамран сургах боловсролын талаарх өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, сургалтын хөтөлбөрийн хэрэгцээг илрүүлнэ.*



## СУДАЛГААНЫ АСУУМЖ-1

**Тэгш хамран сургах боловсролын талаарх ойлголт, хандлага**

Та доорх дүгнэлттэй санал нийлэх үү?

*(Мөр бүрээс тохирох цифрийг дугуйлна уу. Бүрэн санал нийлнэ = 4, Санал нийлнэ = 3, Санал нийлэхгүй = 2, Хэлж мэдэхгүй байна = 1)*

| № | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулна гэдэг нь: | **Хариулт** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Бүрэн санал нийлнэ | Санал нийлнэ | Санал нийлэхгүй | Хариулж мэдэхгүй байна |
| 1.1 | Бүх хүүхдийг боловсролд тэгш хамруулах, суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангахын тулд боловсролын тогтолцоо илүү уян хатан болж өөрчлөгдөх шаардлагатай. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгайлан зориулсан тусгай цэцэрлэг, сургуультай байх нь илүү үр дүнтэй. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.3 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн сургууль, цэцэрлэгт бусад хүүхдүүдтэй хамт суралцах бүрэн боломжтой. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахад цэцэрлэг, сургуулиуд бэлэн биш байна. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшсэн багш нар дутагдалтай байна. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэрээрээ ганцаарчилсан байдлаар суралцах нь илүү үр дүнтэй. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг одоо нийтээр мөрдөж байгаа цэцэрлэг, сургуулийн орчин, сургалтын хөтөлбөрт дасан зохицуулах шаардлагатай. | 4 | 3 | 2 | 1 |
| 1.8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах онцлогт тохирсон хувилбарт хөтөлбөр, үнэлгээ байх ёстой. | 4 | 3 | 2 | 1 |



## СУДАЛГААНЫ АСУУМЖ-2

**Сургалтын байгууллагын бодлого, үйл ажиллагаа**

*(Мөр бүрээс тохирох цифрийг дугуйлна уу. Хангалттай = 4, Дунд зэрэг = 3, Хангалтгүй = 2, Мэдэхгүй = 1)*

| № | Зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа | Хариулт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хангалт-тай | Дунд зэрэг | Хангалт-гүй | Мэдэхгүй |
| 2.1 | Таны бодлоор тэгш хамран сургах эрх зүйн орчин бүрдсэн үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.2 | Орон нутгийн бодлого, хөтөлбөрт тэгш хамран сургах талаар тусгагдсан уу? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.3 | Цэцэрлэг, сургуулийн дотооддоо мөрддөг дүрэм, журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахтай холбоотой зүйл, заалт бий юу? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.4 | Багш, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар тусгасан уу? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.5 | Сургалтын байгууллагын зүгээс хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуулийн насны бүх хүүхдийг боловсролд тэгш хамран сургахад чиглэсэн үйл ажиллагаа, санаачилга өрнүүлдэг үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.6 | Сургалтын байгууллагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх талаар үе тэнгийнхэнд нь сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулдаг уу? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.7 | Сургалтын байгууллагын зүгээс эцэг эх, асран хамгаалагчдаас тэгш хамран сургах боловсролын талаарх ойлголт, хандлагыг илрүүлэх судалгаа авдаг уу? | 4 | 3 | 2 | 1 |
| 2.8 | Сургалтын байгууллагын зүгээс эцэг эх, олон нийт рүү чиглэсэн тэгш хамран сургах боловсролтой холбоотой нөлөөлөл, сурталчилгааны ажил өрнүүлдэг үү? | 4 | 3 | 2 | 1 |



# СУДАЛГААНЫ АСУУМЖ-3

## Сургалтын байгууллагын орчин, хэрэглэгдэхүүн

*(Мөр бүрээс тохирох цифрийг дугуйлна уу. Бүрэн хангасан = 5, Хангасан = 4, Дунд зэрэг = 3, Үгүй = 2, Хэлж мэдэхгүй = 1)*

| № | Цэцэрлэг, сургуулийн орчны бэлэн байдлын үзүүлэлт | **Хариулт** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ханга-сан | Дунд зэрэг | Хангаа-гүй | Хэлж мэдэхгүй |
| 3.1 | Танай байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд саадгүй орж гарах боломжтой юу? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.2 | Танай байгууллагын ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах боломжтой юу? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.3 | Сургуулийн авто зогсоолыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх ашиглах боломжтой юу? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.4 | Онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ажилчдыг сургуулиас аюулгүйгээр, түргэн шуурхай нүүлгэн шилжүүлэх арга замыг бүрдүүлсэн үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.5 | Сургалтын байгууллагын анги танхим, номын сан, урлаг, спортын заал зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчны тохируулга хийгдсэн үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.6 | Цэцэрлэг, сургуулийн автобусаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлдэг үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.7 | Цэцэрлэг, сургууль дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бие даан явж, өөртөө үйлчлэх боломж бүрдсэн үү? | 4 | 3 | 2 | 1 |
| 3.8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжсэн анги зохион байгуулалт, хувийн онцлогт нь тохирсон хөтөлбөр, арга зүй хэрэгждэг үү? | 4 | 3 | 2 | 1 |

**Тайлбар:** *Асуумжийн үр дүнг асуумж (1, 2, 3) тус бүрээр 2 үе шаттай боловсруулна. Эхлээд хүн тус бүрээр, дараа нь сургалтын байгууллагаараа нэгтгэж дундаж оноог гаргана.*
*Байгууллагын дундаж оноо:*
**28.8 - 32** *байвал* **хангалттай**, *соёл болгон бэхжүүлэх*
**25.6 - 28.7** *байвал* **дунд зэрэг**, *үйл ажиллагааг идэвхжүүлэх*
**25.5 - аас** *доош бол* **хангалтгүй**, *бодлого, хөтөлбөрөө сайжруулан, олон талт үйл ажиллагаа зохион байгуулах шаардлагатай байна гэж үзнэ.*



## Явцын үнэлгээ: Багийн үнэлгээний хуудас

Гарааны өөрийн үнэлгээгээр нөхцөл байдлаа тодорхойлсны дараа давуу болон сул талаа илрүүлэх, бусдад түгээх туршлага, сайжруулах арга замаа тодорхойлно.

| № | Үндсэн асуудлууд | Давуу тал | Түгээх туршлага | Сул тал | Сайжруулах санал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тэгш хамран сургах боловсрол - Ойлголт, хандлага | | | | |
| 2 | Тэгш хамран сургах боловсрол - Бодлого, үйл ажиллагаа | | | | |
| 3 | Тэгш хамран сургах боловсрол - Орчин, хэрэглэгдэхүүн, арга зүй | | | | |

## Эцсийн үнэлгээ: Рубрик үнэлгээ 0-4 оноогоор үнэлнэ.

| Шалгуур | 4 оноо | 3 оноо | 2 оноо | 1 оноо | |
|---|---|---|---|---|---|
| Нөхцөл байдлаа илрүүлэх | Туршлага, арга зам дэвшүүлсэн | Давуу, сул талаа тодорхойлсон | Хүн тус бүрээр хийсэн боловч байгууллагаар гаргаагүй | Зааврын дагуу боловсруулаагүй | |
| Дэмжлэгийн баг - Ойлголт, хандлага | Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөлт хийсэн | Нөлөөллийн үр дүнтэй мессэж боловсруулсан | Алдаатай ойлголтоо зассан | Эерэг өөрчлөлт гараагүй | |
| Дэмжлэгийн баг - Бодлого, үйл ажиллагаа | Дэмжлэгийн багийн ажлын төлөвлөгөө боловсруулсан | Үйл ажиллагааны жагсаалт гаргасан | Багаар ажиллаагүй, хэн нэгэнд даалгасан | Шаардлага хангаагүй | |
| Дэмжлэгийн баг - Орчин, арга зүй, хэрэглэгдэхүүн | Оновчтой санал боловсруулж, зарим жишээг гаргасан | Хэрэгцээг тодорхойлж сайжруулах хүрээг гаргасан | Санал, жишээг хуулбарласан, бүтээлч хандаагүй | Санал жишээ гаргаагүй | |
| ГСТ боловсруулж хэрэгжүүлэх арга зүй | ГСТ-г хүүхдийн хувийн онцлогт тохируулан боловсруулсан, эцэг эхийн оролцоог хангасан | ГСТ хэрэгжүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүний оновчтой санаа гаргасан | Загварын дагуу тэмдэглэл хийж хэт ерөнхий боловсруулсан | Арга зүй гаргаагүй | |



## ХОЁР. ЦАГЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Сургалтын дэд агуулга | Нийт цаг | Вебинар сургалт цаг | Вебэд суурилсан цахим сургалт үйл ажиллагааны хуваарилалт, тоо | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Уншиж судлах | Дадлага ажил | Хэлэл-цүүлэг | Видео контент | Үнэлгээ сорил |
| 1 | *ТХСБ - Олон улсын чиг хандлага | **1** | 1 | | | | | |
| 2 | *ТХСБ - Монгол улсын эрх зүйн орчин, хэрэгжилт | **2** | | 2 | | | | |
| 3 | Орон нутаг, сургалтын байгууллагын бодлого, санаачилга | **2** | | | 2 | | | |
| 4 | Хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоог ойлгох нь | **2** | 1 | | | | 1 | |
| 5 | Дэмжлэгийн баг, түүний үндсэн үүрэг | **2** | | 1 | | 1 | | |
| 6 | Дэмжлэгийн багийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам | **2** | 1 | | 1 | | | |
| 7 | ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлж үнэлэх нь | **2** | 1 | | | 1 | | |
| 8 | Тэгш хамран сургах багшийн арга зүй | **2** | | | 1 | 1 | | |
| 9 | Үнэлгээ, даалгавар | **1** | | | | | | |

**Тайлбар:** ***Тэгш хамран сургах боловсрол**

- Вебинар цаг 25%
- Дадлага ажил 25%
- Бие даан уншиж судлах 18.8%
- Хэлэлцүүлэг 18.8%
- Үнэлгээ сорил 6.2%
- Видео контент 6.2%



# ГУРАВ. ДЭД СЭДВИЙН АРГА ЗҮЙН ТӨЛӨВЛӨЛТ

## Дэд сэдэв №1. Тэгш хамран сургах боловсролын олон улсын чиг хандлага

Агуулга:

- Тэгш хамран сургах боловсролын талаарх олон улсын гэрээ, конвенц, санаачилгууд
- Тэгш хамран сургах боловсролын орчин үеийн чиг хандлага
- Тэгш хамран сургах боловсролыг өргөжүүлэх үйл явц

Зорилго: Тэгш хамран сургах боловсролын талаарх олон улсын орчин үеийн чиг хандлага, үнэт зүйлсээс суралцах

Арга зүй: Лекц, хэлэлцүүлэг, мэтгэлцээн

Хугацаа: 45 мин (Вебинар)

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэг-дэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1 Танилцуулга 20 мин | Модулийн ерөнхий танилцуулга. Тэгш хамран сургах боловсролын орчин үеийн чиг хандлагын талаарх мэдээллийг танилцуулах | PP.T 1.1 танилцуулга | Ирц, оролцоо | 1. Тэгш хамран сургах боловсролын талаарх бодлогын хураангуй, БШУЯ, АХБ, БХАН, 2022<br>2. ХБХЭТК-ын Ерөнхий зөвлөмж No.4 |
| Алхам 2 Хэлэлцүүлэг, мэтгэлцээн 20 мин | - Оролцогчдыг багт хувааж дадлага ажил хийлгэнэ.<br>- Зөв бол яагаад, буруу бол хэрхэн засах вэ? хэлэлцүүлэг өрнүүлэх | Алдаатай болон зөв дүгнэлт бичсэн ажлын хуудас - 1.2 | | 2. Багшийн мэргэжил дээшлүүлэх онлайн сургалт - Тэгш хамруулан сургах боловсрол, УБ, 2019<br>(Хуудас 15-22) |
| Алхам 3 Багшийн дүгнэлт 5 мин | - Сургагч багш алдаатай болон тогтсон буруу ойлголтыг засах | PP.T 1.3 | | |

**Тайлбар:** *Дэд сэвдийн хүрээнд хэрэглэгдэх PP.T, ажлын хуудсыг хавсралтаас авч ашиглана уу. Дэд сэдэв бүрээр PP.T, ажлын хуудас, дасгал даалгавар, сорил үнэлгээг кодлон дугаарлана.*



## Дэд сэдэв №2. Тэгш хамран сургах боловсрол - Эрх зүйн орчин, хэрэгжилт

Агуулга:
- Тэгш хамран сургах боловсролын талаарх эрх зүйн орчин
- Тэгш хамран сургах боловсролын эрх зүйн хэрэгжилт
- Хэрэгжилтийг ханган ажиллах арга зам, санал санаачилга, туршлага

Зорилго: Монгол улсад баримталж буй тэгш хамран сургах боловсролын талаарх бодлого, эрх зүйтэй танилцаж, хэрэгжилтийг ханган ажиллахад оролцоо, үүргээ эргэн харах

Арга зүй: Баримт мэдээлэлтэй ажиллах арга

Хугацаа: 90 мин (бие даан уншиж, судлах)

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэг-дэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1 Бүтээлч уншлага 45 мин | - Оролцогчдыг ажиллаж байгаа байгууллага, албан тушаалаар нь багт хуваах<br>- Эрх зүйн эмхэтгэлээс унших хэсгийг тодорхой зааж өгөх | PDF материал 2.1 Тэмдэглэл хөтлөх ажлын хуудас 2 | Багуудын бэлтгэсэн танилцуул-гын үр дүн | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2022 |
| Алхам 2 Багийн нэгтгэл, оюуны зураглал 40 мин | - Өгөгдсөн ажлын хуудсын дагуу хүн бүр тэмдэглэл хийх<br>- Багаараа нэгтгэж танилцуулах | Багуудын танилцуулга | | |
| Алхам 3 Дүгнэлт 5 мин | Сургагч багш дүгнэлт хийж эрх зүйн баримт бичгийн тойм танилцуулах | PP.T 2.3 | | |

**Тайлбар:** Оролцогчдыг ажилладаг байгууллага, албан тушаал, чиг үүргээр нь баг болгон хувааж, дараах байдлаар унших материалыг тодорхой зааж өгч, ажлын хуудаст тэмдэглэл хөтлөх заавриг танилцуулна. Жишээ нь: **“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”**- ээс унших даалгаврыг баг тус бүрт хуудас зааж өгнө.
- Цэцэрлэг: хуудас 79-84, 153-158
- Сургууль: хуудас 51-57, 64-68, 84-87,139-151
- Боловсролын газар, хэлтэс: хуудас 75-77, 84-87, 119-123
- Салбар комисс: хуудас 103-118
- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл: хуудас 119-123 гэх мэт



## Дэд сэдэв №3. Орон нутаг, сургалтын байгууллагын бодлого, санаачилга

Агуулга:

- Орон нутаг, сургалтын байгууллагын дотооддоо мөрддөг баримт бичигт шинжилгээ хийнэ.
- Тэгш хамран сургах боловсролын талаарх олон улсын үзэл баримтлал, өөрийн орны хууль, эрх зүйг орон нутаг, байгууллагын бодлого хөтөлбөр, дүрэм журамд тусгах санал боловсруулна.

Зорилго: Орон нутаг, сургалтын байгууллагын бодлого хөтөлбөр, дүрэм журамд тэгш хамран сургах боловсролын талаар тусган, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх

Арга зүй: Шинжлэн судлах, зэрэгцсэн тэмдэглэл хөтлөх арга

Хугацаа: 90 мин (дадлага ажил)

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1<br>45 мин<br>Баримт бичгийн шинжилгээ | Оролцогчдыг байгууллага, албан тушаалаар нь баг болгон хуваах<br><br>1. Дор дурдсан баримт бичгээс аль нэгийг хэвлэж авч ирэх даалгавар урьдчилан өгөх:<br><br>- Орон нутгийн хөтөлбөр<br><br>- БШУГ, Боловсролын хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө | - Орон нутаг, сургалтын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод хэм хэмжээг агуулсан баримт бичгүүд<br><br>Ажлын хуудас 3.1 | Багийн гүйцэтгэл, баримт бичгийн шинжилгээний үр дүн | - Алсын хараа 2050<br><br>- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030<br><br>- БШУЯ-ны 2022-2023 оны шинэ хичээлийн жилийн зорилго, зорилт |



| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Сургалтын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод хэм хэмжээ<br><br>- Багш, ажилтны ажил албан тушаал, ажлын байрны тодорхойлолт<br><br>2. Оролцогчдыг багт хувааж баримт бичгүүдэд тэгш хамран сургах боловсролын асуудлыг тусгасан эсэхийг шинжлэн судалж тэмдэглэл хөтлөх | | | - Өмнөх сэдвүүдээр үзэж судалсан тэгш хамран сургах боловсролын талаарх олон улсын үзэл баримтлал, өөрийн орны бодлого, эрх зүйн баримт бичигт хийсэн багуудын шинжилгээ |
| Алхам 2<br>45 мин<br>Санал боловсруу-лах | - Орон нутаг, сургалтын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод хэм хэмжээний баримт бичигт тэгш хамран сургах боловсролын асуудлыг тусган хэрэгжүүлэх талаар санал боловсруулж багаараа танилцуулах | Багуудын танилцуулга | Саналын төсөл | - Сургалтын өмнөх АСУУЛГА 1.2.3-ын үр дүнг харгалзан үзэхийг санал болгох |



## Дэд сэдэв №4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоог ойлгох нь

Агуулга:

- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэхэд эцэг эх, өрхийн эмнэлгийн үүрэг оролцоо
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх төрөлжсөн нарийн мэргэжлийн багийн үйл ажиллагаа
- Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг төлөвлөж, шийдвэрлэх салбар комисс, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны уялдаа холбоо

Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц дэмжлэг үзүүлэхэд оролцогч талуудын зохион байгуулалт, үүргийг танилцуулах, хамтран уялдаатай ажиллахад арга зүйн дэмжлэг үзүүлэх

Арга зүй: Дүрд тоглох, кейстэй ажиллах

Хугацаа: 90 мин (видео контент, вебинар хичээл)

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам1 15 мин Видео үзэх | “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоо” видеог үзэж тэмдэглэл хөтлөх | Видео 4.1 Холбоос | Бичсэн тэмдэглэл | |
| Алхам 2 30 мин *INSERT тэмдэглэлгээ хийх | Чиглүүлэх асуултын дагуу уншиж тэмдэглэл хөтлөх | Унших материал 4.2 | Асуултын дагуух хариулт | ХНХ, БШУ, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал А/220, А/475, А/812 Хавсралт 1 2021 оны 12 дугаар сарын 30 |
| Алхам 3 30 мин Кейстэй ажиллах | Оролцогчдыг багт хувааж өгөгдсөн кейст үзүүлэх дэмжлэг үйл ажиллагааг дүрд тоглон төлөвлөн шийдвэрлэх | Кейс 4.3 | Үйл ажиллагааны төлөвлөлт, авах арга хэмжээ | |
| Алхам 4 15 мин Сургагч багшийн дүгнэлт зөвлөмж | Нэмэлт тайлбар, алдаатай ойлголтыг засах, зарим орон нутаг, сургалтын байгууллагын туршлага танилцуулах | Багшийн мэдээлэл 4.4 | | |

*INSERT арга- унших явцад бүтээлч тэмдэглэгээ хийх арга.



## Хичээлийн удирдамж:

Багш хичээлийн дараалал, цагийн төлөвлөлтийг танилцуулна. Видео контент үзэж, сонсох, insert тэмдэглэгээ хөтлөх - 45 мин

1. Багшийн бэлтгэсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоо” видеог анхааралтай үзэж, сонсоно.
2. ХНХ, БШУ, ЭМ-ийн сайдын хамтарсан А/220, А/475, А/812 тоот тушаалын Хавсралт 1-ийг уншиж INSERT аргаар тэмдэглэл хөтөлнө. (Унших материал PDF 4.2)

| Агуулга | Мэддэг байсан | Шинээр мэдсэн | Эргэлзээтэй ойлголт | Асуулт |
|---|---|---|---|---|
| Дэмжлэг үзүүлэх үе шат | | | | |
| Эрт илрүүлэг хийх нас | | | | |
| Үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан | | | | |
| Үйл ажиллагааны уялдаа хоорондын хамаарал | | | | |

3. Кейстэй ажиллах, дүрд тоглох - 30 мин

Оролцогчдыг дараах байдлаар 5 багт хувааж, хүн бүрд дүр оноож, хаягжуулсан байна.

- 1. Эцэг эх, гэр бүл
- 2. Сум, өрхийн эмнэлэг
- 3. II, III шатлалын эмнэлэг
- 2. Салбар комисс
- 5. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл

*Хүүхэлдэйгээр хүүхдийг төлөөлүүлэн ашиглана.*

Өгөгдсөн кейсийг сайтар уншаад, дэмжлэг үзүүлэх бүтцүүд хэрхэн ажиллах, ямар арга хэмжээ авах талаар дүрд тоглон шийдвэрлэнэ.



Дүрд тоглох замаар дараах асуултад хариулсан байна:

I - О-ийн гэр бүлд шинэ мэндэлсэн хүүхдэд ямар онцлог илэрсэн бэ?

II - Хичээлээр үзэж судалсан ойлголт, мэдлэг, чадвараа ашиглан энэ гэр бүл, хүүхдэд дэмжлэг, үйлчилгээг танай баг үзүүлнэ үү.

- Хамгийн түрүүнд хаана, хэнд хандах вэ?
- Өрх, сумын эмнэлэг ямар арга хэмжээ авч, ямар шийдвэр гаргах вэ?
- II, III шатлалын эмнэлэг ямар зохион байгуулалтаар хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ?
- Аймаг, дүүргийн салбар комисс бодит дэмжлэг хэрхэн үзүүлэх вэ?
- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл ямар бэлтгэл хангаж ажиллах вэ?
- Асуудлыг шийдвэрлэхэд ямар бэрхшээл тулгарсан бэ?
- Тулгарсан бэрхшээлийг арилгах ямар боломжууд байна вэ?
- Хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх ямар арга замууд байж болох вэ?

Хэрэглэгдэхүүн: 4.3:

Кейс

О-ийн гэр бүлд шинэ хүн мэндэллээ. Сумын эмнэлэгт амаржсан ээж, хүүхдийн бие сайн. ... Хүүхдийн бие бялдрын өсөлт хэвийн, хөдөлгөөн сайтай, эрүүл мэндийн тулгамдсан асуудалгүй 3 сар хүрлээ.

... Ямар ч чанга чимээнд сэрэлгүй унтдаг. Энэ нь ээжид амар санагддаг учраас бусад хүүхдүүдээс минь өөр, их тайван хүүхэд шүү гэж өхөөрддөг.

... Нэрээр нь дуудах болон чимээ гарсан зүгт анхаарч хардаггүй, уйлж тавгүйтдэггүй учир эцэг эх нь төдийлөн санаа зовдоггүй. Хүүхдээ 5 сартайд “Эх, хүүхдийн ягаан дэвтэр”-ийн асуумж бөглөж байхдаа ээж, аав нь хүүхдээ илүү анзаарах ёстойгоо ойлгосон.

4. Хөгжлийн цогц дэмжлэг үзүүлж буй орон нутаг, сургалтын байгууллагын зарим сайн жишээ илрүүлэх, танилцуулах - 15 минут

- Танай орон нутаг, сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлж буй ямар сайн жишээ байгаа вэ?

**Багшийн мэдээлэл 4.4**

Судалгааны тайланд дурдагдсан дараах туршлагыг танилцуулна.

**Эх сурвалж:** *Ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамран сургах*



*боловсрол хэрэгжиж буй өнөөгийн нөхцөл байдал, бий болсон сайн туршлага", Улаанбаатар, 2021*

**Эрт илрүүлэг, оношилгоо**

Төв суурин газарт ирж эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдаж чадахгүй, мэдээлэл хүрэхгүй байгаа алслагдсан нутаг сум, багт амьдарч байгаа хүүхдэд хүрч ажиллахад зарим орон нутаг сайн санаачилга гаргасан байна. Тухайлбал:

**Өвөрхангай аймаг:**

Салбар комисс нь ХБХЭЭХ-ны аймгийн салбартай хамтран эрт илрүүлэг, оношилгооны "Явуулын үйлчилгээ" зохион байгуулж, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийг зохих үйлчилгээнд хамруулан холбогдох байгууллагуудад холбон зуучилжээ.

**Дэмжлэгийн үйлчилгээг төлөвлөж, шийдвэрлэх**

**Хөвсгөл аймаг:**

Салбар комисс, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнийг оруулснаар орчин хэрэглэгдэхүүнтэй холбоотой санхүүжилтээ шийдвэрлэ-сэн байна. Мөн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь жилд 2 удаа хуралдаж хэвшсэн бөгөөд жил бүрийн 5 дугаар сард шийдвэрлэх асуудлаа хэлэлцэж, хичээлийн шинэ жил эхлэхэд тэгш хамран сургах бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллах журмаа аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулжээ.

**Баянхонгор аймаг:**

Боловсролд хамрагддаггүй цэцэрлэг, сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өдөр бүр 2 цагийн хөгжүүлэх сургалт зохион байгуулдаг.

**Баян-Өлгий аймаг:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг мэргэжилтэн урьж ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг нийслэл, орон нутгийн сайн туршлагатай байгууллагаас туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулжээ.

**Дорнод аймаг:**

Өөрийн аймагт хэрэгжүүлж туршсан, үр дүнгээ өгсөн үйл ажиллагааг

ойролцоох аймгуудтай туршлага хуваалцах, ном, гарын авлага гарган түгээх, гадаад мэргэжилтэн урьж ажиллуулах зэрэг үйл ажиллагаа зохион байгуулсан.

### Орхон аймаг:

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, сургалтын байгууллагын удирдлагуудыг хамруулсан мэргэжлийн байгууллагуудаас нэгдсэн сургалт авсан. Голлох эрх зүйн баримт бичгийн холбогдох чиг үүргийг оролцогч талуудад хүргэх брошур бүхий “Тэмдэглэлийн дэвтэр”-ийг хэвлэсэн. Бүх дэмжлэгийн багийн гишүүдэд шаталсан сургалт зохион байгуулж, чадавх бэхжүүлсэн.

### Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг:

ЕБС-ийн удирдлага, нийгмийн ажилтан, эмч нарт тэгш хамран сургах боловсролын чиглэлээрх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ойлголт хандлага, асуудал бэрхшээлээ хэлэлцэж, энэ талаар туршлага хуримтлуулж буй дүүргийн сургуулиудаас туршлага судлах ажлыг хэрэгжүүлдэг.

### Өвөрхангай аймгийн 2 дугаар сургууль:

Дэмжлэгийн багийн гишүүд хүүхэд хөгжлийн жишиг танхим байгуулан, өдөр бүр цагийн хуваарийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч хөгжих, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах ажлыг тогтмол зохион байгуулдаг. Тохирох хэрэглэгдэхүүн боловсруулах уралдаан зарлан, үзэсгэлэн гаргаснаар багш нар бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлсэн.

### Ховд аймаг:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцахад учирч буй орчны саад арилгахын тулд сургуулиуд өөрсдийн боломжид тулгуурлан тохируулгуудыг хийсэн.

### Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Ирээдүй” цогцолбор сургууль:

Сурагчдын өөрийн удирдлагын байгууллагын санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг амжилттай суралцаж хөгжихөд нь дэм болох “Үе тэнгийнхний эерэг нөлөө” сургалтыг зохион байгуулж 6-12 дугаар ангийн 3221 сурагч хамруулсан.



## Дэд сэдэв №5. Дэмжлэгийн баг, түүний үндсэн үүрэг

Агуулга:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх бүтэц тогтолцоо
- Боловсролын дэмжлэг үзүүлэх Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, БШУГ/Боловсролын хэлтэс, Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоо
- Дэмжлэгийн багийн үндсэн үүргийг цэцэрлэг, сургууль дээр хэрэгжүүлэх үйл явцын зураглал гаргах

Арга зүй: Тонгоруу сургалтын арга

Хугацаа: 90 мин (Уншиж судлах 45 минут, хэлэлцүүлэг 45 мин)

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэг дэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1<br>45 мин<br>Уншиж судлах | - Багш сэдэвтэй холбоотой уншиж судлах материалыг оролцогчдод урьдчилан хүргэсэн байх<br>- Оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловс-ролын дэмжлэг үзүүлэх<br>- Үйл явцын тойм зураглал гаргах даалгаврыг хос хосоороо гүйцэтгэх | Унших материал 5.1 | Үйл явцын зураглал хийсэн байдал | БСШУС-ын сайдын А/292 тоот тушаал 2019 он |
| Алхам 2<br>45 мин | Оролцогчид багт хуваагдана. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1 кейс сонгон авах<br>(5 мин)<br>- Өмнө гүйцэтгэсэн Үйл явцын зураглал дээрээ бодит кейсээ тавьж дахин сайжруулалт хийх (15 мин)<br>- Дэмжлэгийн баг кейст дурдагдсан хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар аргачлал бэлтгэн танилцуулж хэлэлцүүлэх (25 мин) | Үйл явцын зураглал хийх жишээ | Аргачлал бэлтгэсэн танилцуулга | Жаргал. Ч; (2021) Тэгш хамран сургахад багшид туслах арга зүй, хуудас 102-111 |

**Үйл явцын зураглал гэдэг нь үйл явц, ажлын явцыг дүрсэлсэн зураглал юм.*

Унших материал 5.1 Бүтээлчээр тэмдэглэл хөтлөн уншина.

- Хос, хосоороо хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх тогтолцооны Үйл явцын зураглал хийж хэлэлцүүлэгт танилцуулна.



# ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХАД ОРОН НУТАГ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА ХЭРХЭН АЖИЛЛАХ ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх үйл явцын 4 дэх үе шат болох хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээг үзүүлэхэд сургалтын байгууллага, түүний удирдах ажилтан, багш илүү үүрэг хүлээнэ. Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг (i) Суурь үйлчилгээ, (ii) Зорилтот үйлчилгээ гэж ангилж болох бөгөөд сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль суурь үйлчилгээг үзүүлнэ. Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан идэвхтэй сурч боловсрох нөхцөлийг хангахын тулд тохирох хэрэглэгдэхүүн, тохируулгат орчинг урьдчилан бүрдүүлэх шаардлагатай байдаг. Хөгжлийн онцлог ялгаатай хүүхдийг суралцах, тоглох, аливаа үйл ажиллагаанд оролцох, үе тэнгийнхэнтэйгээ харилцах, үерхэж нөхөрлөх боломжоор аль болох бага наснаас нь хангаснаар тэдний хувьд хөгжих хамгийн сайн нөхцөл боломж бүрддэг.

## Хаанаас эхлэх вэ?

Цэцэрлэг, сургуульд хамрагдаж байгаа хүүхдэд хөгжлийн онцлог ялгаа илэрч байгаа эсэхэд ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөн, түүнийг олон талаас нь судална. Ажиглалтыг иж бүрэн хийгээгүй хэрнээ эцэг эхэд “танай хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй” гэж хэлэх нь багш, эцэг эхчүүдийн хооронд харилцааны бэрхшээл үүсгэдэг. Хоцрогдолтой хүүхдэд илэрч буй байдал нь хүүхдийн хэвийн хөгжлөөс хэт ялгаатай байвал эцэг эхэд эрүүл мэндийн байгууллага болон холбогдох мэргэжилтэнд хандахыг зөвлөхөөс эхлэх хэрэгтэй. Сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ирсэн тохиолдолд л хийнэ гэж хүлээлгүйгээр тэгш хүртээмжтэй орчныг урьдчилан бүрдүүлсэн байх шаардлагатай.

## Үүнийг сургалтын байгууллагын бэлэн байдал гэж нэрлэдэг.

- Барилга байгууламжийн саадыг арилгах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх
- Суралцахуйн түгээмэл загварыг хичээлд ашиглах, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх
- Олон талт байдлыг харилцан хүлээн зөвшөөрдөг анги, бүлэг, цэцэрлэг, сургуулийг дэмжих хандлагыг бий болгох зэргээр тэгш хамран сургах боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэх материаллаг хийгээд сэтгэл зүйн орчныг тогтмол бүрдүүлж байхаас гадна багшлах боловсон хүчний нөөц, арга зүйн хөгжлийн төлөвлөгөө, алсын хараатай байх шаардлагатай.



## Зохион байгуулалтыг хэрхэн хийх вэ?

### 1. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд элсүүлэх үйл явцыг зохион байгуулахдаа Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг тухайн шатны Засаг даргын тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй байгуулна:

- Засаг даргын ажлын албаны төлөөлөл эсвэл Засаг даргын Тамгын газрын төлөөлөл /Зөвлөлийн дарга/
- Тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын тэгш хамран сургах сургалт хариуцсан мэргэжилтэн /Нарийн бичгийн дарга/
- Салбар комиссын боловсрол хариуцсан гишүүн
- Салбар комиссын эрүүл мэнд хариуцсан гишүүн
- Тухайн орон нутгийн цэцэрлэг, сургуулийн удирдлагын төлөөлөл
- Эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл.

### Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрал, ахуйн нөхцөл, суралцах онцлог хэрэгцээг судлан хэлэлцэж холбогдох маягтад тэмдэглэх;
- Хүүхдэд шаардагдах эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын гэх мэт нэмэлт дэмжлэг, боловсролд хамрагдахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг тодорхойлж холбогдох үйлчилгээнд хамруулах зохицуулалт хийх;
- Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан боловсролд хамрагдах сургалтын байгууллага, суралцах арга, хэлбэрийг сонгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвд хамруулах;
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг баримтлах;
- Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдийг гэр бүлийн орчинд суурилсан боловсролын үйлчилгээ /сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт, сургууль, насан туршийн боловсролын явуулын багшийн үйлчилгээ г.м/-д хамруулах шийдвэр гаргаж баталгаажуулах.

Зөвлөл шийдвэрээ гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь эсвэл зорилтот үйлчилгээнд хамруулах талаар эцэг эхийн саналыг



харгалзан холбон зуучилна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахаар сонгосон цэцэрлэг, сургуулийн зүгээс барилга байгууламж, анги танхимын орчин нөхцөл тохиромжгүй, бэлтгэгдсэн багш байхгүй, тохирох ном сурах бичиг хангалтгүй зэргээр шалтаглан хүүхэд элсүүлж авахаас татгалзаж болохгүй.

### 2. Боловсролын газар/хэлтсийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Орон нутгийн хэмжээнд тэгш хамран сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг удирдлагаар хангах;
- Тэгш хамран сургах боловсролыг дэмжих агуулгаар сургалтын байгууллагын багш, ажилтны мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, тэднийг арга зүйн удирдлагаар хангах;
- Багш нарыг хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах арга зүйгээр хангах, бага ангиас дунд ангид дэвшин суралцах хүүхдэд сэтгэл зүйн болон дасан зохицох дэмжлэг үзүүлэх агуулгаар чадавхжуулах;
- Бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг нэгтгэх;
- Сургалтын байгууллагуудын дунд туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах:

### 3. Сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн багийн хэрэгжүүлэх чиг үүрэг:

- Дэмжлэг шаардлагатай хүүхдийг тодорхойлох;
- Хүүхдийн эрүүл мэндийн болон орчин нөхцөлийн судалгаа хийх;
- Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн санал, зөвлөмжид үндэслэн боловсруулж, үр дүнг тайлагнах;
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;
- Шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг судлах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалтын байгууллагын удирдлагатай хамтран ажиллах;
- Багш, эцэг эх, асран хамгаалагч, иргэдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээллээр хангах.



Сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд зориулан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахаас гадна хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн байгаа эсэхэд хяналт тавина. Тус баг нь улиралд нэг удаа хуралдаж,

> Цэцэрлэг, сургууль нь хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус 7-9 хүний бүрэлдэхүүнтэй “Дэмжлэгийн баг”-ийг байгуулж ажиллана.

ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг засаж сайжруулах болон цаашдын чиглэлийг хэлэлцэх ба үр дүнг Боловсрол, шинжлэх ухааны газар/Боловсролын хэлтэст тайлагнана. Сургууль, цэцэрлэг нь өөрийн дотоод нөөц бололцоогоор тохирох хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд боловсролын байгууллага, эрүүл мэнд, халамжийн мэргэжилтэн, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж шийдвэрлэнэ.

> Тохирох хэрэглэгдэхүүн гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлнэ
>
> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4.1.3

Тэгш хамран сургах боловсролыг чанартай хэрэгжүүлэхэд сургууль, цэцэрлэгийн бэлэн байдал, дэмжлэгийн орчинг хэрхэн бүрдүүлэх талаар энэ хичээлээр танилцууллаа.



Үйл явцын зураглалын жишээг эндээс харна уу. *Тайлбар: Тухайн үйл ажиллагаа хэрхэн хийгдэхийг тайлбарлаж, дүрслэн харуулах алхмууд, даалгаврын гүйцэтгэх эздийг тодорхойлох, ажил эхлэх, дуусах хугацаа зэргийг агуулдаг.*



## Дэд сэдэв №6. Дэмжлэгийн багийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам

Агуулга:

- Тэгш хамран сургахтай холбоотой сургалтын байгууллага дээрх тулгамдсан асуудал
- Сургалтын байгууллагын одоогийн нөхцөл байдлын үнэлгээ
- Бодит кейс дээр өмнө хийсэн үйл явцын зураглалын сайжруулалт
- Өмнө олж авсан мэдлэг, ойлголтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулалт

Арга зүй: *PDCA-аар төлөвлөх

Хугацаа: 90 мин (Вебинар 45 минут, хэлэлцүүлэг 45 мин)

*Plan, Do, Check, Act - Төлөвлө, Хий, Үнэл, Сайжруул

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1<br>45 мин<br>Багшийн мэдээлэл | - Багш өмнө үзсэн сэдвүүдийг бататган үзэл баримтлал, эрх зүйн орчин, орон нутаг сургалтын байгууллагын нөхцөл байдлаа тодорхойлсныг сануулж, хэрэгжилтийг хангахад “Дэмжлэгийн баг”-ийн үйл ажиллагааг төлөвлөн ажиллах нь чухлыг ойлгуулна.<br>- Сургууль, цэцэрлэг дээрх тэгш хамруулахтай холбоотой ямар, ямар асуудлууд байгааг илрүүлэх асуулга google form-оор авч нэгтгэнэ. Үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тулгамдсан асуудлын хувьд тодорхой үр дүнд хүрсэн байхаар төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх PP.T танилцуулна. | Google form асуулга 6.1<br><br>PP.T 6.2 | Тулгамдсан асуудлаа илрүүлж буй байдал | Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй<br><br>http://igovernment.mn/docs/176 Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллаж буй сайн туршлага, УБ, 2020 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Алхам 2<br>45 мин<br>Хэлэлцүү-лэг | Оролцогчид багт хуваагдана.<br>- Сургалтын байгууллага дээрх дэмжлэг шаардлагатай хүүхдийн 1 кейс сонгон авна.<br>(5 мин)<br>- Өмнө гүйцэтгэсэн үйл явцын зураглал дээр бодит кейсээ тавьж дахин сайжруулалт хийнэ.<br>(15 мин)<br>- Дэмжлэгийн багийн жишиг төлөвлөгөөг бэлтгэн танилцуулж хэлэлцүүлнэ.<br>(25 мин) | Кейс<br>Оролцог-чид өөрсдөө гаргана<br><br>Ажлын хуудас 6.3 | Жилийн төлөвлөгөө-ний төсөл танилцуулга | Тэгш хамран сургах боловсрол – Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийн судалгаа (УБ ., 2022) |

Алхам 1 хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Асуулгыг Google form-оор авч үр дүнг тэр дор нь нэгтгэнэ.

*Тайлбар: Цэцэрлэг, сургуулийн тэгш хамран сургахад тулгамддаг асуудлыг илрүүлэхийн тулд дараах асуултыг бэлтгэсэн байна. (ТИЙМ, ҮГҮЙ) хариултаас сонгохоор байна.*

**АСУУЛТУУД 6.1**

Хүрээ 1: Бодлого, хэрэгжилт

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн тухайд цэцэрлэг, сургуулийн "Дэмжлэгийн баг"-ийн төлөвлөгөөтэй юу?

Хүрээ 2: Мэдээлэл

Танай цэцэрлэг, сургууль сүүлийн нэг жилийн хугацаанд элсэж байгаа болон одоо суралцаж байгаа сурагчдын дунд хүүхдийн эрсдэл, бэрхшээлийг илрүүлэх (тусгай хэрэгцээтэй байж болзошгүй хүүхдийг таньж илрүүлэх) ямар нэгэн үнэлгээ хийсэн үү?

Хүрээ 3: Удирдлага, менежмент

Эрхлэгч, захирал тэгш хамран сургах шаардлагатай дэмжлэгийн систем цэцэрлэг, сургууль дээр байгаа гэж үздэг үү?

Хүрээ 4: Санхүү

Цэцэрлэг, сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих нэмэлт санхүүжилт авдаг уу?

Хүрээ 5: Дэд бүтэц

Цэцэрлэг, сургуулийн анги танхим, барилга дэд бүтэц бүх хүүхэд ашиглахад тохиромжтой юу?



### Хүрээ 6: Суралцахуйн дэмжлэг

Цэцэрлэг, сургууль эцэг эхтэй хэрхэн харьцаж, холбоо барьдаг вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд үзүүлдэг ямар нэгэн дэмжлэг бий юу?

### Хүрээ 7: Үзлэг

Аливаа нэг хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүйг багш таамаглавал, эсвэл ямар нэг мэргэжлийн дэмжлэг хэрэгтэй байгааг, эсвэл тусгай хэрэгсэл шаардлагатайг мэдвэл хэнд хандах нь тодорхой байдаг уу?

### Хүрээ 8: Үнэлгээ

Танай цэцэрлэг, сургуулийн дотоод үнэлгээний дүрэм журамд тусгасан хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн үнэлэх аргачлал байдаг уу?

### Хүрээ 9: Багш нар

Та ангийнхаа бүх хүүхдэд хичээл заахад тохирох чадварыг эзэмшсэн гэж боддог уу? Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэхэд танд тулгардаг бэрхшээл бий юу?

### Хүрээ 10: Хандлага

Бүх хүүхэд хамтдаа суралцах ёстой гэж багш нар итгэдэг үү? Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахад тулгардаг хамгийн том бэрхшээл юу гэж та бодож байна вэ? (Нэгийг сонгоорой)

- Сөрөг хандлага
- Үзлэг, оношилгооны дутагдал
- Багшийн арга зүй, туршлага дутмаг байдал
- Дэмжих үйлчилгээний дутагдал
- Бусад ........................................

Алхам 2 хэрэгжүүлэх үйл ажиллагаа PP.T 6.1-ийг танилцуулна. Хавсралтаас дэмжлэгийн багийн үйл ажиллагааны жишиг төлөвлөлтийн загвартай танилцаж, өөрийн сургалтын байгууллагын **“Дэмжлэгийн баг”**-ийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулна.

## Дэд сэдэв №7. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах

### Агуулга:

- ГСТ гэж юу вэ? (зорилго, бүтэц, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим)
- ГСТ боловсруулахад анхаарах зүйлс
- ГСТ хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс
- ГСТ хөтөлбөрийн үнэлгээ хэрхэн хийх (баримт бичгүүдтэй танилцах, жишээ тайлбар)



Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохируулан чанартай боловсрол эзэмшихэд нь туслах ГСТ-г хэрхэн боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, юуг анхаарах зэргийг бодит жишээн дээр тайлбарлан таниулах.
Арга зүй: Хэлэлцүүлэг, лекц

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1 20 мин Хэлэл-цүүлэг | Асуултын дагуу тулгамдаж буй асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн туршлагаа хуваалцах | Бэлтгэсэн асуултууд | Оролцогч-дын хариулт | БСШУС-ын сайдын А/155 (2018) А/292 (2019) А/425 (2018) тоот тушаалууд |
| Алхам 2 15 мин Тэмдэг-лэл хөтлөх | ГСТ-ний зорилго, бүтэц, хугацаа болон баримтлах зарчмуудыг жишээгээр тайлбарлах | ГСТ-ний загвар PP.T 7.1 | Тэмдэглэгээ | |
| Алхам 3 25 мин Жишээ-тэй танилцах | Хүүхдийн бодит байдлыг үнэлэх, зорилго, зорилтыг дэвшүүлэхэд анхаарах зүйлс, ялгаатай дасгалын аргыг хэрхэн хэрэглэх | ГСТ болон нэгж ээлжит хичээлийн хөтөлбөр | Дэвшүүлсэн санал, тэмдэглэл | |
| Алхам 4 25 мин Дүгнэлт | ГСТ-ний хэрэгжүүлэх орчны зураглал, явцын болон эцсийн үнэлгээ хийх бичиг баримтуудтай танилцах, сэдвийн дүгнэлт хийх | Багшийн мэдээлэл PP.T 7.2 | | |
| Алхам 5 10 мин Нээлттэй асуултууд | Багш оролцогчдын сонирхсон асуултад нээлттэй хариулах | | | |



## Үйл ажиллагаа:

1. Багш хичээлийн сэдвийн агуулгыг танилцуулж, оролцогчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад тулгамдаж буй асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх туршлагаа ярилцах
2. ГСТ-ний зорилго, бүтэц, хугацаа болон баримтлах зарчмуудыг жишээгээр тайлбарлах
3. ГСТ боловсруулах арга зүйг боловсруулсан хөтөлбөрийн жишээгээр тайлбарлах
4. ГСТ хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс: ГСТ хэрэгжих орчны зураглал дээр дэмжлэгийн баг болон эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо, хамтын ажиллагааг тайлбарлах
5. ГСТ-ний хөтөлбөрийн үнэлгээг хэрхэн хийх журмуудтай танилцах. ГСТ боловсруулан ажилласан багшийн урамшууллыг хэрхэн олгох журмыг тайлбарлах.



## Дэд сэдэв №8. Тэгш хамран сургах багшийн арга зүй

Агуулга:
- Хүүхэд бүрийн сурах онцлог, хэрэгцээнд тохируулан хөтөлбөрөө төлөвлөх, боловсруулах
- Хүүхэд бүрийн оролцоог хангасан сургалтын арга зүйг тодорхойлж, хэрэглэгдэхүүн бэлтгэх нь (бодит жишээгээр)
- Хүүхэд бүрийн суралцахуйн онцлогийг харгалзан ялгаатай дасгалууд боловсруулах
- Тэгш хамруулан сургахад тулгамдаж буй асуудал болон аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, туршлага

Зорилго: Хүүхэд бүрийн тэгш оролцоог хангаж, суралцахуйн ялгаатай сурагчдад хичээл заах болон дасгал даалгавар боловсруулахдаа ашиглаж болох сонирхолтой аргуудыг танилцуулах

Арга зүй: Вебинар, дадлага

Хугацаа: 90 мин

| Алхам | Үйл ажиллагаа | Хэрэглэгдэхүүн | Үнэлгээ | Бие даан судлах материал |
|---|---|---|---|---|
| Алхам 1<br>10 мин<br>Хэлэл-цүүлэг | Сурагч бүрийн хэрэгцээг тодорхойлох арга зүй, хөгжлийн онцлогийг харгалзан хөтөлбөр боловсруулах үе шат | PP.T 8.1 Багшийн туршлага жишээ | Санал бодлоо хуваалцах | БСШУС-ын сайдын А/155 тушаал Хавсралт 1, 2 |
| Алхам 2<br>10 мин | Дүрслэх урлаг, технологи хичээлээр судлагдахууны агуулгад тохируулан хэл яриа, танин мэдэхүй, тооцоолох болон зурах, бичих чадварыг сурагчдын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн бэлтгэсэн ээлжит хичээлийн бодит жишээтэй танилцах | | Оролцогч-дын хариулт | “Ээлжит хичээлийн загвар”, ЖАЙКА, 2017<br><br>“Тэгш хамруулан сургахад багшид туслах арга зүй “ (Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, 2020) |



| | | | | |
|---|---|---|---|---|
| Алхам 3<br>20 мин<br>Жишээтэй танилцах | Монгол хэлний хичээл “Эх дээр ажиллах”, “Холбоо үг, өгүүлбэр бүтээх”, “Үг унших, тогтоох хөгжилтэй арга” | | | “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” гарын авлага, ЖАЙКА, УБ, 2018 |
| Алхам 4<br>10 мин | Дадлага 1<br>Дүр зургаар тогтоох нь карт тоглоом бэлтгэх | | Багийн хамтын ажиллагаа оролцоо | |
| Алхам 5<br>5 мин | Дүрслэн тогтоох арга | | | |
| Алхам 6<br>5 мин | Дадлага 2<br>Дууны үг ба шүлэг | | | |
| Алхам 7<br>30 мин | Аутизмтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, дадлага | PP.T 8.2 | | Үгээр хязгаарлагдахгүй харилцаа, Ферн Суссман, 2015 |

## Үйл ажиллагаа:

1. Хэрэгцээ - Оролцоо - Үнэлгээ
   Сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн, технологи нь хүүхдийн оролцоонд тулгуурлан бүтээгдэх учиртай. Учир нь хүүхдийн оролцох явцад гарсан үйл үйлдлийг судалж, түүнд тохируулан бэлтгэсэн “юм” бүхэн үр дүнгээ өгдөг. Сургалтын явцад сурагчид мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, сэргээн санах зэрэг нь харилцан адилгүй байдаг тул тэдэнд тохирсон хувилбараар мэдээллийг өгч дасгал даалгаврыг боловсруулах нь тэгш хамран сургаж багшлах арга зүйн нэг хэсэг болдог. Сурагч бүрийн хэрэгцээнд тулгуурлан, оролцоог хангаж хичээл сургалтыг зохион байгуулах нь хамгийн чухал бөгөөд сурагчдад нэг ижил хичээл хийж байгаа сэтгэгдэл төрүүлэх нь гол зорилго болохыг онцлоод хөтөлбөр хэрхэн бичих үе шатуудыг жишээгээр тайлбарлана.
2. Дүрслэх урлаг, технологийн хичээл “Тахир шугам” сэдвийг хүүхэд бүрийн хэрэгцээнд хэрхэн тохируулж бэлтгэсэн талаар сурагчдын бүтээлийг харуулан тайлбарлах

## Монгол хэлний хичээлээр эх дээр ажиллах

Хүүхдийн аль чадвар, ямар мэдрэхүйн эрхтэнд тулгуурлаж сургалтаа явуулах нь хүүхдээ судлахаас эхэлдэг. Аль болох хүүхдийн онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, ажлын хуудас бэлтгэнэ. Сургалтын тохирох хэрэглэгдэхүүн нь хүүхэд ашиглаж чадах, ойлгоход хялбар төвөггүй

хэрнээ сургалтын хөтөлбөрт заасан чадварыг эзэмшүүлж байх шаардлагатайг ямагт анхаарна. Хүүхдийн бодит чадварт тохироогүй хэт хүнд, эсвэл хэт хялбар байвал тэд сонирхдоггүй.

Эх хэлний хичээл нь эхэд суурилан явагдах нь илүү үр дүнтэй байдаг. Багш эхийн утгыг ерөнхийлөн дараах байдлаар хэлж өгнө: Эхэд 6 амьтан гарна. Тэд эх дэлхийдээ хэн нь илүү ашигтайг ээлжлэн хэлнэ.

### “Амьтдын маргаан”

Эх дэлхийдээ хэн нь хамгийн ашигтай амьтан болох талаар амьтад маргалдаж гэнэ.

Зөгий: Зөгийн бал бол энэ дэлхийн хамгийн амттай бас хамгийн ашигтай хүнс.

Тоншуул: Хэрвээ би өдөржин өт түүх ажлаа зогсоовол модод өгрөөд уначих байлгүй.

Шоргоолж: Бид л хөрсөөр нэг тарж давхиж байж сийрэгжүүлэлт хийж байна шүү дээ. Тэгээд л ийм гоё цэцэг, ногоо алаглаж байгааг та нар харж байгаа байх.

Туулай: Муу үндсийг нь түүж хаяхгүй бол тэр гоё цэцэг ногоо чинь бас үхчихнэ шүү дээ.

Эрвээхэй: Би ч гэсэн өдөржин цэцгийн үр зөөж нисдэг.

Арслан: Одоо маргаанаа зогсооцгоо. Энэ дэлхийн хамгийн ухаант амьтан бол хоёр хөлтэй Хоохондой. Тэр л ухаанаараа биднийг шүүх болно гэв.






Дүрүүдийг гарч буй дарааллаар нь сонсоод тэмдэглэх. Тоо мэддэг сурагчид 1, 2, 3, 4, 5, 6 гэж тэмдэглэнэ. Бичих боломжгүй саажилттай сурагчид стикер ашиглаж болно. Мөн хуруугаар ажлын хуудсаа толболох эсвэл баримаалдаж болно. Оюун ухааны хүнд хэлбэрийн бэрхшээлтэй бол “Туулай хаана байна? Туулайг олоорой” гэх мэт багшийн чиглүүлэг асуултын дагуу тухайн амьтныг олж тэмдэглэнэ.




Уншсан, сонссон эхээрээ бяцхан ном хийх дараагийн даалгаварт шилжинэ. Хүүхэд бүр өөрийн чадварт тохируулан дээрх зургийн дагуу даалгавраа гүйцэтгэх ба амьтан бүрийн онцлогийг жишээгээр тайлбарлана.

## Монгол хэлний хичээл – Үг, холбоо үг

Багшийн үгийг давтан хэлэх эсвэл үгийг зөвхөн нэг, нэгээгр хэлдэг сурагчдад бичиж сурсан үгэн дээр тохирох зураг наах, үг нэмэх замаар өгүүлбэр бүтээх аргыг хэрэглэнэ. Эхлээд үгэн дээр зураг нэмэх зарчмаар



холбоо үг үүсгэнэ. Дараа нь холбоо үгээс өгүүлбэр бүтээж өгүүлбэрийн түвшинд ярихыг зорино. Тэгээд өгүүлбэрээ дэлгэрүүлэх зарчмаар эх бүтээхэд шилжинэ. Ажлын хуудсыг зурагт харуулснаар хийнэ.

Хүүхэд бүрийн бичих чадвар харилцан адилгүй байдаг тул багш хүүхдүүдийн хийж чадах хувилбараар дасгалыг боловсруулахыг эрмэлзэж байх хэрэгтэй. Хэдийгээр үг бичиж чадахгүй ч зураг нэрлэж, зургаар холбоо үг, өгүүлбэр бүтээн хэлж, дүрс, өнгө, зураг зэргийг нааж гүйцэтгэж болох талаар тайлбарлана.



### Дадлага 1. Дүр, зургаар тогтоох нь

Мэдрэхүйг харааны, сонсголын, хөдөлгөөний, амтлах, үнэрлэх, сэтгэл хөдлөлийн хэмээн ангилдаг. Мэдээллийг хурдан тогтоож цаашлаад урт хугацааны ойдоо хадгалан түргэн сэргээн санахад хараанаас гадна сэтгэл хөдлөлийг ашиглах нь тустай байдаг. Дараах хэрэглэгдэхүүнийг тоглоом хэлбэрээр бэлтгэсэн нь сурагчдын уншиж, бичиж сурах хугацааг хурдасгасан давуу талтай юм. “Memory game” буюу ой тогтоолтын тоглоом нь 2 зургийг ижилсүүлэх хэлбэрээр тоглодог 2,5-аас дээш насны хүүхдэд зориулсан тоглоом юм. Уг тоглоомыг тоглох зарчим дээрхтэй ижил боловч **зураг - үг** гэсэн хэлбэрээр бэлтгэсэн нь сурагчдыг сонирхолтой хэлбэрээр унших, бичихэд туслах бөгөөд хүүхдүүд үүнийг унших дасгал биш тоглоом гэсэн үүднээс харж залхахгүйгээр хурдан суралцдаг. Оролцогчдын тооноос хамаарч тэднийг 4-5 багт хувааж, баг багаар нь нэг ширээнд суулгана. Дараа нь оролцогч тус бүрд 2 хос жижиг дөрвөлжин цаас тарааж өгөх ба тэд нэг







цаасан дээр зураг зурж, нөгөө цаасан дээр зурсан тухайн зүйлийнхээ нэрийг бичсэн карт бүтээж багаараа тоглоно.

## Мэдээллийг харааны ойгоор дамжуулан хүлээн авах, тогтоох

Мэдрэх эрхтний оролцоотойгоор хүмүүсийн юмсыг тогтоох, сэргээн санах байдал өөр, өөр байдаг. Хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл яриагаар хүртэж танин мэдэх нь ялгаатай. Оюун ухааны хүнд, хүндэвтэр болон суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд юмсыг ойлгон хүлээн авахдаа сонсохоос илүү **харж ойлгох** нь хялбар байдаг. Иймээс тэдэнд



Ц.Дамдинсүрэн “Монгол нутаг”



П.Бадарч “Есөн эрдэнийн орон”



Оньсого, зүйр үг, дуу, шүлэг




мэдээллийг зурган хэлбэрээр хүргэхэд хялбар бөгөөд хугацааны хувьд хэмнэлттэй байдаг.

Оюун ухаан, хэл ярианы бэрхшээлтэй, ой тогтоолт удаан, уншиж хараахан сураагүй, уншаад ойлгох чадвар сул сурагчдын хувьд дуу, шүлэг цээжлэх, дууны аянд нь амжиж дуулахад нь хүндрэлтэй байдаг. Иймээс дуу, шүлгийг зургаар дүрслэх нь хурдан цээжлэх, сэргээн санахад нь тус болдог талаар тайлбарлан зураг дээрх хэлбэрүүдийг жишээ болгон үзүүлнэ. Дараа нь 2 дахь дадлага ажилд шилжинэ.

## Дадлага 2

Багш самбарт “Бөөн баяр” дууны үгийг зурж бэлтгэсэн байх бөгөөд зургийг хараад оролцогчид багшийн хамт дуулна.



### Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах арга зүй

Багш аутизмын хүрээний эмгэгийн ерөнхий ойлголт буюу төрөл, бэрхшээлүүд, мэдрэхүйн онцлог байдлын талаар товч дурдаад ойлгомжгүй зан үйлүүдийг ажиглах, багасгах арга зүй болон зурган карт солилцооны арга-харилцаанд орж хүслээ илэрхийлэхэд нь туслах, харааг ашиглан бэлтгэж болох орчны тохируулгыг зурагт жишээгээр тайлбарлана. Мөн төсөөлөн бодоход туслах арга зүй, хөдөлгөөний чадварыг сайжруулах арга зүйн туршлагаа хуваалцана.

### Дадлага 3

Оролцогчид багшийн заавраар “Сайн байна уу?” хүүхдийн дууг дохио оролцуулан дуулна.

## Дэд сэдэв №9. Үнэлгээ

Зорилго:

- Өмнө үзэж судалж, бүтээж боловсруулсан үйлдлээ нэгтгэж багаараа

сургалтын эцсийн үнэлгээг хийнэ.
- Дараах рубрикээр оролцогч багууд харилцан бие биенээ үнэлж, зөвлөгөө өгнө.

Сургалтын явц дахь тэмдэглэл, боловсруулалт, хэрэглэгдэхүүн, уншиж судлах материалаар файл болон цаасаар хавтас үүсгэн нэгтгэж үйл ажиллагаандаа ашиглана.

### Эцсийн үнэлгээ: Рубрик үнэлгээ 0-4 оноогоор үнэлнэ.

| Шалгуур | 4 оноо | 3 оноо | 2 оноо | 1 оноо | Авсан оноо |
|---|---|---|---|---|---|
| Нөхцөл байдлаа илрүүлэх | Туршлага, арга зам дэвшүүлсэн | Давуу, сул талаа тодорхойлсон | Хүн тус бүр болон байгууллагаар гаргасан | Зааврын дагуу боловсруулаагүй | |
| Дэмжлэгийн баг - Ойлголт, хандлага | Нөлөөллийн үйл ажиллагааы төлөвлөлт хийсэн | Нөлөөллийн үр дүнтэй мессэж боловсруулсан | Алдаатай ойлголтоо зассан | Эерэг өөрчлөлт гараагүй | |
| Дэмжлэгийн баг - Бодлого, үйл ажиллагаа | Дэмжлэгийн багийн ажлын төлөвлөгөө боловсруулсан | Үйл ажиллагааны жагсаалт гаргасан | Багаар ажиллаагүй, хэн нэгэнд даалгасан | Шаардлага хангаагүй | |
| Дэмжлэгийн баг - Орчин, арга зүй, хэрэглэгдэхүүн | Оновчтой санал боловсруулж, зарим жишээг гаргасан | Хэрэгцээг тодорхойлж сайжруулах хүрээг гаргасан | Санал, жишээг хуулбарласан, бүтээлч хандаагүй | Санал жишээ гаргаагүй | |
| ГСТ боловсруулж хэрэгжүүлэх арга зүй | ГСТ-г хүүхдийн хувийн онцлогт тохируулан боловсруулсан, эцэг эхийн оролцоог хангасан, үнэлгээ хийх боломж бүрдүүлсэн | ГСТ-нд хүүхдийг оновчтой тодорхойлж кейс хэлэлцүүлж арга зүй, хэрэглэгдэхүүн оновчтой санаа гаргасан | Загварын дагуу тэмдэглэл хийж хэт ерөнхий боловсруулсан | Арга зүй гаргаагүй | |
| **Нийт оноо:** | | | | | |



### Хэрэглэгдэхүүний жагсаалт

Дэд сэдэв 1: Тэгш хамран сургах боловсролын олон улсын чиг хандлага

1.1 Тэгш хамран сургах боловсролын орчин үеийн чиг хандлага (PP.T)

1.2 Тэгш хамран сургах боловсролын  талаарх ойлголт, хандлага (ажлын хуудас)

1.3  Ойлголт, хандлага нэмэлт мэдээлэл (PP.T)

Дэд сэдэв 2: Тэгш хамран сургах боловсрол - Монгол улсын эрх зүйн орчин, хэрэгжилт

2.1 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл (унших материал PDF)

2.2 Тэгш хамран сургах боловсрол - Монгол улсын эрх зүйн орчин, хэрэгжилт (ажлын хуудас )

2.3 Эрх зүйн баримт бичгийн тойм (PP.T)

Дэд сэдэв 3: Тэгш хамран сургах боловсрол - Орон нутаг, сургалтын байгууллагын бодлого, санаачилга

3.1 Орон нутгийн сургалтын байгууллагын дотоод хэм хэмжээг агуулсан баримт бичгүүдэд шинжилгээ хийх (ажлын хуудас)

Дэд сэдэв 4: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоог ойлгох нь

4.1 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоо” (PP.T)

4.2 Дүрд тоглон дэмжлэг үзүүлэх  (Кейс)

4.3 Зарим орон нутаг, сургалтын байгууллагын туршлага (багшийн мэдээлэл)

Дэд сэдэв 5: Дэмжлэгийн баг, түүний үндсэн үүрэг

5.1 Боловсролын дэмжлэг үзүүлэх арга зам (багшийн мэдээлэл)

5.2 Үйл явцын зураглал хиих (жишээ схем зураг)

Дэд сэдэв 6: Дэмжлэгийн багийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам

6.1 Цэцэрлэг, сургууль дээр тэгш хамруулахтай холбоотой ямар ямар асуудлууд (асуулга google form-оор авч, үр дүнг нэгтгэнэ)

6.2 Үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн байхаар төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх (PP.T)

6.3 Дэмжлэгийн багийн жишиг төлөвлөгөө (төлөвлөгөөний загвар)

Дэд сэдэв 7: Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) боловсруулах

7.1 ГСТ-ний зорилго, бүтэц, хугацаа болон баримтлах зарчмуудыг жишээгээр тайлбарлах (PP.T)

7.2 ГСТ-ний хэрэгжүүлэх орчны зураглал, явцын болон эцсийн үнэлгээ хийх (загвар жишээ)

Дэд сэдэв 8: Тэгш хамран сургах багшийн арга зүй

8.1 Сурагч бүрийн хэрэгцээг тодорхойлох арга зүй, хөгжлийн онцлогийг харгалзан хөтөлбөр боловсруулах үе шатууд (PP.T)

8.2 Аутизмтай хүүхэдтэй ажиллах арга зүй дадлага (PP.T)

Дэд сэдэв 9: Үнэлгээ

9.1 Рубрик үнэлгээний шалгуур хүснэгт (эцсийн үнэлгээ хийх хүснэгт)




ADB
Japan Fund for Poverty Reduction
From the People of Japan
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
Тэгш хамран сургах боловсрол:
Олон улсын чиг хандлага
АХБ БТ9208-МОН: Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл
Бүрэлдэхүүн хэсэг 3: Тэгш хамруулах боловсролыг дэмжих эх үүсвэр, нөөц, олон нийтийн оролцоо ба бодлого
“ ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ
ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН МОДУЛЬ”
Модуль сургалтын материал 1.1


БОЛОВСРОЛ?
ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ?

Тэмдэглэл:
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................




Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
• НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 1946 онд баталсан
• 26 дугаар зүйл: Боловсрол
➔Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон суурь боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой.
➔Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх ... энх тайвныг сахиулахад дөхөм үзүүлэх ёстой
Эрхээ мэдэж байх хэрэгтэй
3


Хүүхдийн эрхийн конвенц
• 1989 онд батлагдсан; Монгол Улс 1990 онд нэгдэн орсон
• Хүүхдийн үзэл бодлыг үргэлж харгалзан үзэх ёстойг заасан анхны олон улсын гэрээ
• Сурч боловсрох эрхийг онцолсон
• адил тэгш боломжоор хангах
• хүүхдийн чадавхыг бүрэн төгс хөгжүүлэх
4

Тэмдэглэл:
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................
..............................................................................................................



## Саламанка-гийн тунхаглал

- 1994 оны 6 дугаар сард
- 92 орон, 25 олон улсын байгууллагын төлөөлөгчид
- Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэм, сэтгэл зүй, хэлний болон бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан бүх хүүхдийг **ердийн** сургуульд хүлээн авч сургах талаар санал нэгдсэн.
- Боловсролын бүхий л бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд **‘хөгжлийн бэрхшээлгүй байсан бол хамрагдах ёстой байсан’** гэр орныхоо дэргэдэх тэр л сургуульд суралцах ёстойг тунхагласан.

5

## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (ХБХЭТК), 2006

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (ХБХЭТК) нь шинээр ямар нэгэн эрхийг танилцуулаагүй – харин өмнө нь тунхагласан эрхүүдийг дахин баталгаажуулж, засгийн газруудын зүгээс тэдгээрийн хэрэгжилтийг хангах нэмэлт үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

Сурч боловсрох эрхийн талаарх тусгайлсан заалт (24 дүгээр зүйл) нь “бүхий л түвшинд тэгш хамран сургах боловсролын тогтолцоо”-г баталгаажуулахыг зорьсон.

**ХБХЭТК нь тэгш хамран сургах боловсролыг эрх хэмээн онцлон дэмжсэн олон улсын түвшний хамгийн анхны хууль эрх зүйн акт юм.**

6

Тэмдэглэл:



## ХБХЭТК 24 дүгээр зүйл

Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах үүрэг хүлээнэ. Энэхүү үүргийг ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр, адил тэгш боломжийн үндсэн дээр хангахдаа Оролцогч улсууд нь бүх түвшинд болон насан туршийн суралцахуйн үйл явцад дараах зорилго бүхий тэгш хамран сургах боловсролын тогтолцоог баталгаажуулах үүрэг хүлээнэ:

а) хувь хүний чадвар, чадамжийг бүрэн дүүрэн хөгжүүлэх

б) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие хүн төлөвшилт, авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээ болон оюун ухаан, бие бялдрын хөгжлийг хамгийн боломжит дээд хэмжээнд хөгжүүлэх

в) чөлөөт нийгэмд үр дүнтэй оролцох.

7




*ТХЗ 4 – Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих*

Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийг хангахын тулд хүүхэд нэг бүрийг шаардлагатай нөхцөлөөр хангаж чадах илүү тэгш хамруулсан, илүү тэгш боломжоор хангасан бөгөөд илүү өндөр чанартай боловсролын тогтолцоо руу аажмаар шилжих үүрэг хариуцлага

8

Тэмдэглэл:

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................



Education 2030

## Тогтвортой Хөгжлийн Зорилго 4

**Зорилтын хүрэх үр дүн [7]**

4.1 **Бүх нийтэд чанартай бага, дунд боловсрол олгох**

4.2 **Бага насны хүүхдийн хөгжил ба сургуулийн өмнөх боловсрол**

4.3 Техник, мэргэжлийн болон дээд боловсролд тэгш хамрагдах

4.4 Ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадвар эзэмших

4.5 **Жендерийн тэгш байдал ба тэгш боломжоор хангах**

4.6 Залуучууд болон насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх

4.7 **Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн иргэншлийн боловсрол**

**Хэрэгжүүлэх арга зам [3]**

4.а **Аюулгүй, тэгш хамруулсан суралцах орчин**

4.б Дээд боловсролд хамрагдах тэтгэлэгт хөтөлбөрүүд

4.в **Багшийг чадавх, тэдний ажиллах нөхцөл**

## ХБХЭТК 24 дүгээр зүйл: Сурч боловсрох эрх

Улс орнууд нь дараах зүйлсийг баталгаажуулах үүрэгтэй:

- сурч боловсрох эрхийг **алагчлалгүйгээр, адил тэгш боломжийн** үндсэн дээр хангах
- **тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бүхий л түвшинд** хөгжүүлэх
- **тохируулгат хэрэглэгдэхүүн** болон **ганцаарчилсан дэмжлэгийн арга хэмжээнүүдээр** хангах
- боловсрол болон олон нийтийн үйл ажиллагаанд **тэгш оролцоход** шаардлагатай ур чадвар эзэмших боломжоор хангах
- шаардлагатай ур чадвар бүхий мэргэшсэн **багш нараар** хангах
- **аажмаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэх**

Тэмдэглэл:

........................................................................................................................

........................................................................................................................

........................................................................................................................

........................................................................................................................

........................................................................................................................

........................................................................................................................

........................................................................................................................




Ерөнхий зөвлөмж #4-ийг яагаад бичих болсон бэ?
НҮБ-аас 2016 онд баталсан ХБХЭТК – урагш тэмүүлсэн томоохон эрс өөрчлөлт
24 дугээр зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа алагчлалгүйгээр, бусадтай нэгэн адил тэгш хамруулсан боловсрол эзэмших эрхийг тунхагласан
Гэвч хэрэгжилтэд томоохон бэрхшээлүүд тулгарсан: алагчлал; гадуурхал; олон талт саад бэрхшээлүүд; сул ойлголт; тоо баримт байхгүй; тэгш хамруулалтыг ойлгохгүй байх
2015 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонос 24 дүгээр зүйлийг илүү тодруулах шийдвэр гаргасан
2016 оны 8 дугаар сард Ерөнхий зөвлөмж #4-ийг баталсан


Тэгш хамран сургах боловсрол гэж юу вэ?
Хүний үндсэн эрх
Бүх суралцагчдад адил тэгш хандах зарчим
Бусад эрхүүдийг бодит болгох арга зам
Сурч боловсрох эрхээ эдлэхэд тулгарч буй саад бэрхшээлүүдийг арилгахад чиглэсэн зорилтот үйл явцын үр дүн

Тэмдэглэл:

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................




Ерөнхий зөвлөмж 4: Тэгш хамран сургах боловсролын үндсэн шинж чанарууд
Тогтолцоо
• Тогтолцоо бүхэлдээ арга хандлага
• Боловсролын орчинг иж бүрнээр нь авч үзэх
• Хувь хүнийг цогцоор нь авч үзсэн хандлага
Орчин
• Багш нарт дэмжлэг үзүүлэх
• Ялгаатай байдлыг үнэлж хүндэтгэх
• Суралцах үйлийг дэмжсэн ээлтэй орчин
Тогтвортой байдал
• Үр дүнтэй шилжилт өөрчлөлт
• Түншлэлийг хөгжүүлэх
• Байнгын хяналт-шинжилгэ


Хэрэгжилтэд шаардлагатай арга хэмжээ
Бүтэц ба тогтолцоо
Хууль эрх зүй ба бодлого
Төлөвлөлт ба тоо баримт, мэдээлэл цуглуулах
Нөөц боломж
Багш боловсрол ба дэмжлэг
Суралцагчийн үнэлгээ
Үүрэг хариуцлага ба хяналт-шинжилгээ

Тэмдэглэл:

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................



## Хууль эрх зүй ба бодлого

- Хүний эрхийн стандартуудтай нийцсэн байх
- Тэгш хамран сургах боловсролыг тодорхойлох болон тэгш хамран сургах боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах
- Интститутчиллыг хүчингүй болгох үүрэг амлалт
- Хүртээмж болон зохих дэмжлэг үзүүлэх явдлыг баталгаажуулах
- Чанарын цогц стандартууд
- Тохирох хэрэглэгдэхүүн шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Эрт илрүүлэлт болон дэмжлэгийн хүрээ
- Бүхий л суралцагчдад зориулан үйлчилгээг төлөвлөж хүргэх орон нутгийн удирдлагуудын үүрэг хариуцлага
- Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулах
- Гол талуудтай түншлэлийг байгуулах

## Төлөвлөлт ба тоо баримт, мэдээлэл цуглуулах




Тэмдэглэл:
.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................
.................................................................................................................................




Нөөц боломж
Хангалттай санхүүгийн болон хүний нөөцөөр хангах үүрэг амлалт
Засаглал ба санхүүжилтийн тогтолцооны шинэчлэл
Тусгай боловсролын нөөцийг тэгш хамруулсан боловсролын орчинд шилжүүлэх
Хувийн салбартай түншлэх
Хүртээмжтэй/саадгүй нэвтрүүлэх суралцахуйн орчинг дэмжих
Тэгш хамран сургах багшийг бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийх
Хүртээмжтэй суралцахуйг дэмжих нөөц, туслах хэрэглэгдэхүүнээр хангах
Доромжлол, гадуурхалт бүхий асуудлыг шийдвэрлэх


Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ба дэмжлэг үзүүлэх
• Бүх багш нар
• Боловсролын бүх түвшин
• Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх
• Тусгайлсан модулиуд ба үйл ажиллагаанаасаа/хийнгээ/суралцах
Сургалт хэнд чиглэх
Сургалтын агуулга
• Жишээ нь: Хүний ялгаатай байдал ба хүний эрх
• Тэгш хамруулан заах арга зүй
• Харилцааны хэлбэр ба тохируулан өөрчилсөн сургалтын аргууд
• Ганцаарчилсан сургалт явуулах
• Сургуулиудын хоорондын түншлэл
• Багаар хамтран хичээл заах
• Багш нар хамтран үнэлгээ хийх
• Эцэг эхчүүдийг оролцуулах
• Орон нутгийн иргэдтэй
Багшид дэмжлэг үзүүлэх

Тэмдэглэл:

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................




Үүрэг хариуцлага ба хяналт-шинжилгээ
Үүрэг хариуцлага
Эрхийн талаарх мэдээлэл ба зөрчлийг хэрхэн шийдвэрлэх
Гомдол гаргах болон шийдвэрлэх аюулгүй, хүртээмжтэй, шударга, үр дүнтэй механизм
Хууль эрх зүйн дэмжлэг авах боломж
Тэгш хамран сургах боловсролын ахицыг хэмжих хяналт-шинжилгээний хүрээ


Тэгш хамран сургах боловсрол дахь дэмжлэгийн тогтолцоо
Нэмэлт арга хэмжээ
Сонгон авах арга хэмжээ
Бүх хүнд чиглэсэн арга хэмжээ

Тэмдэглэл:
.................................................................................................................
.................................................................................................................
.................................................................................................................
.................................................................................................................
.................................................................................................................
.................................................................................................................
.................................................................................................................



## Тэгш хамран сургах боловсрол дахь дэмжлэгийн тогтолцоо




Багшийн анги танхимдаа хэрэгжүүлдэг **бүх суралцагчийн** хувьд боломжтой байдаг бүхий л арга хэмжээ. Багшийн өдөр тутмын хичээлийн үйл ажиллагаандаа, сурагчдынхаа зан үйлийн дүрэм журамд, тэдний гүйцэтгэх дасгал даалгаварт, хичээлийн үеэр ганцаарчлан ба багаар ажиллах үед үзүүлдэг дэмжлэгтээ ... хийдэг бүхий л өөрчлөлт зохицуулалтууд.

**Суралцахуйн түгээмэл загвар бол үүний нэг хэсэг юм.**

## Тэгш хамран сургах боловсрол дахь дэмжлэгийн тогтолцоо




**Зарим суралцагчийн хувьд** бүх хүнд чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байдаг тул суралцахуйг нь баталгаажуулахын тулд дэмжлэгийн дараагийн үе шатыг идэвхжүүлж болно. Эдгээр 'сонгон авах арга хэмжээ' нь сургуулийн түвшинд боломжтой байх нөөцүүдийг ашиглан суралцахуйг дэмжих нэмэлт дэмжлэг болно: сургалтын хөтөлбөрт жижиг өөрчлөлт оруулах, ганцаарчилсан ба жижиг бүлгээр давтлага өгөх г.м.

Тэмдэглэл:

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................

.......................................................................................................................



## Тэгш хамран сургах боловсрол дахь дэмжлэгийн тогтолцоо




Суралцагчид бүх нийтэд чиглэсэн ба сонгон авах арга хэмжээ нь хангалтгүй тохиолдолд суралцах үйл явцыг нь дэмжихийн тулд нэмэлт арга хэмжээ (ихэвчлэн тусгай боловсролын үйлчилгээ гэдэг) авч эхлэх үйл ажиллагаанд холбон зуучилж болно. Илүү эрчимтэй ийм төрлийн дэмжлэг авах шаардлагатай **цөөхөн суралцагч** байдаг.

## Тэгш хамруулсан тогтолцоо дахь Тусгай боловсролын үүрэг (нэмэлт дэмжлэг)

Уламжлалт тусгай боловсрол нь ердийн сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байдлаар (практик үйл ажиллагаа ба агуулгын хувьд) өөрчлөн шинэчлэгдэж байна:

- Суралцах хэв маягийг (хараа, сонсгол, хүрэлцэж мэдрэх гм.) тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ердийн сургалтын хөтөлбөрт тохируулга хийх г.м.) боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Шаардлагатай нэмэлт дэмжлэг (хэл яриа, ахуйн баримжаа олгох, хөдөлгөөн засал г.м.)-ийг тодорхойлох
- Суралцагч, гэр бүл, сургууль, үйлчилгээ & олон нийтийн хооронд уялдаа холбоо үүсгэх

Багш нартай хамтран ажиллах (суралцагчидтай гэхээс илүүтэйгээр) ба суралцагчидтай ховор тохиолдолд шууд харилцах (аль болох бага)

Тэмдэглэл:
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................
..........................................................................................................



## Суралцагчийн үнэлгээ

- Стандартчилсан үнэлгээний оронд үнэлгээний уян хатан бөгөөд олон хэлбэрийг ашиглах ба суралцахуйн хувилбарт арга замыг хангах өргөн хүрээний зорилгод чиглэсэн хувь хүний ахицыг хүлээн зөвшөөрөх
- Суралцагчийн тэгш хамруулсан үнэлгээний тогтолцоог ганцаарчилсан дэмжлэгийн тогтолцоогоор улам сайжруулах боломжтой.






АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

Тэмдэглэл:

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

..........................................................................................

## ХАВСРАЛТ

### Ажлын хуудас - 1.2 ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ ХАНДЛАГА

Дараах дүгнэлтийг тийм, үгүй эсэхээр нь тодорхойлж Яагаад? гэдэгт тайлбар бичээрэй.

| Дүгнэлтүүд | Тийм | Үгүй | Яагаад? тайлбар |
|---|---|---|---|
| Уламжлалт тусгай боловсролын тогтолцоо нь “Хүүхэд бол асуудал” – хүүхэд өөрөө тогтолцоотой нийцэх хэрэгтэй гэсэн ойлголт дээр тулгуурладаг. | | | |
| Тэгш хамран сургах боловсрол нь хүүхдийг асуудал гэж үзэхээс илүүтэйгээр боломжит шийдлүүдийг идэвхтэйгээр тодорхойлохын тулд “тогтолцоо бол асуудал” гэж үздэг. | | | |
| Ердийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцах нь бусад сурагчдын хичээлдээ зарцуулах цагт сөргөөр нөлөөлдөг. | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй сурагчид хамтран суралцах нь харилцааны ур чадвар, биеийн хөдөлгөөний хөгжил, бусдыг ойлгож хүндлэх зэрэгт хэрэгтэй дэмжлэг, урам зоригийг бие биедээ өгдөггүй. | | | |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцахад нь тусалснаар тэдэнд туслаагүй сурагчдаас илүү гүнзгий мэдлэг, ур чадвартай болдог. | | | |
| Тэгш хамруулсан орчинд суралцсан сурагчид тэгш эрхийн мэдрэмж, туршлагатай болсноор нийтийн дунд цагаа өнгөрөөх, тасралтгүй суралцахдаа дургүй болдог. | | | |

ADB
Japan Fund for Poverty Reduction
From the People of Japan
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
Mongolian Education Alliance
Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

# Тэгш хамран сургах боловсрол: Ойлголт хандлага

АХБ БТ9208-МОН: Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл

Бүрэлдэхүүн хэсэг 3: Тэгш хамруулах боловсролыг дэмжих эх үүсвэр, нөөц, олон нийтийн оролцоо ба бодлого

" ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН МОДУЛЬ"

Модуль сургалтын материал 1.3




Тэмдэглэл:

........................................................................................................................................

........................................................................................................................................

........................................................................................................................................

........................................................................................................................................

........................................................................................................................................

........................................................................................................................................

........................................................................................................................................

## Аажмаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэх



ХБХЭТК бол хөгжлийн бэрхшээлтэй БҮХ хүний БҮХ эрхийг аажмаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулахыг зорьсон хууль эрх зүйн хэрэгсэл.

## Буруу ойлголт 1



Тэмдэглэл:

..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................
..........................................................................................................................................



## Буруу ойлголт 2



*Интеграцчилал ба Тэгш хамруулалт*
*нь* ***ижил утгатай биш***



## Тэгш хамруулах/ Inclusion

**ЦОРЫН ГАНЦ "тойрог" байна. Энэ тойрогт ялгаатай байдлаас үл хамааран бүх хүн багтах ба тэд зорилго, үүрэг хариуцлага нэгтэй.**



Тэмдэглэл:



## Тэгш хамран сургах боловсролын үр өгөөж (суралцагчдын хувьд)

**Хөгжлийн бэрхшээлгүй сурагчид**

- Ердийн ангид хөгжлийн хүнд бэрхшээлтэй хүүхдүүд суралцах нь бусад сурагчдын хичээлдээ зарцуулах цагт сөргөөр нөлөөлдөггүй
- Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийнхэндээ багаар ажиллах үед дэмжлэг үзүүлсэн сурагчид хөгжлийн бэрхшээлтэй сурагчид суралцдаггүй ангийн хүүхдүүдийн хичээлийн гүйцэтгэлийн түвшинтэй ижил түвшинд байдаг
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй (ХБХ)** найзалж нөхөрлөдөг хүүхдүүд ихэнхдээ ийм туршлага хуримтлуулаагүй бол мэдэхгүй байсан ухагдахууны талаар ойлголт мэдлэгтэй болж илүү хүсэл эрмэлзлэлтэй болсон байдаг
- ХБХ-д суралцахад нь тусалснаар идэвхгүй суралцаж буй бусад ихэнх хүүхдүүдээс илүү гүнзгий мэдлэг, ур чадвартай болдог

**Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид**

- ГСТ-өөс харахад сурлагын амжилт нь сайн байх хандлага өндөр байдаг
- Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй сурагчид хамтран ажиллах нь энгийн харилцааны ур чадвар болон биеийн хөдөлгөөний хөгжилд хэрэгтэй дэмжлэг, урам зоригийг өгдөг
- Тэгш хамруулсан орчинд сурагчид илүү их тэгш хамруулсан туршлагатай болж, нийтийн дунд илүү цаг өнгөрөөх дуртай болдог
- Тусгаарлагдсан орчинд суралцдаг ХБХ-тэй харьцуулахад онолын мэдлэгийн хувьд илүү ихийг сурдаг
- Тусгай сургуультай харьцуулахад ихэнхдээ илүү өргөн хүрээтэй бөгөөд илүү уян хатан сургалтын хөтөлбөрөөр суралцаж, сурлагын амжилтын хувьд илүү өндөр хүлээлттэй байдаг

## Тэгш хамран сургах боловсролын үр өгөөж (бусад хүмүүсийн хувьд)

**Багш нар**

- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдынхаа хувьд илүү өндөр хүлээлт тавьдаг (тусгаарлагдсан орчинтой харьцуулахад)
- ХБХ-ийг тэгш хамран сургахтай холбоотой багшийн мэдлэг, ур чадвар нь сайжирснаар бүх сурагчдын суралцахуйд (хүлээлт ба үр дүн)-д эергээр нөлөөлдөг

**Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

- (бүх хүний хувьд) насан туршдаа бие даан амьдрахад нь хэрэгтэй нийгэм-сэтгэл зүйн гол ур чадваруудыг зөвхөн тэгш хамруулсан орчинд л эзэмших боломжтой
- Хүүхдүүд илүү эерэг харилцаатай болж, нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх зан үйл, хэм хэмжээний талаар илүү сайн ойлгож, нийгэм-сэтгэл зүйн өндөр цогц чадамжтай болдог

**Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

- ДНБ-ий алдагдлыг ойролцоогоор 5–7% бууруулдаг (үр дүн ба орлогын алдагдал), нийгмийн халамжид үзүүлэх дарамт буурдаг
- Боловсролын зардлыг бууруулдаг – тусгай сургуульд 7–9 дахин илүү зардал зарцуулдаг; тусгай боловсролд хамрагдаж буй 1 сурагчид зарцуулах зардал ердийн сургуулийн сурагчийнхаас 2.5 дахин өндөр байдаг.

Тэмдэглэл:

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................



Уламжлалт ердийн болон тусгай боловсролын тогтолцоо нь "Хүүхэд бол асуудал" – хүүхэд өөрөө тогтолцоотой нийцэх хэрэгтэй гэсэн ойлголт дээр тулгуурладаг.




Тэгш хамран сургах боловсрол нь хүүхдийг асуудал гэж үзэхээс илүүтэйгээр боломжит шийдлүүдийг идэвхтэйгээр тодорхойлохын тулд "**тогтолцоо бол асуудал**" гэж үздэг.




Тэмдэглэл:

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................

.....................................................................................................................



## 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл (унших материал PDF)

Энэ холбоосоор орж уншина уу? https://online.pubhtml5.com/pacj/orsr/

Тэмдэглэл:



Ажлын хуудас - 2.2 ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ - МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ

- Монгол улсад тэгш хамран сургах чиглэлээр мөрдөгдөж байгаа эрх зүйн баримт бичгийг хос, хосоороо тэмдэглэл хөтлөн уншина.
- Баримт бичгүүдийн хоорондын холбоо хамаарлыг шинжлэн, оюуны зураглалын аргаар багаараа нэгтгэн танилцуулга бэлтгэнэ.

........................ажил албан тушаал, чиг үүрэг

| № | Эрх зүйн баримт бичгийн нэр дугаар | Батлагдсан он | Ямар хэм хэмжээ, харилцааг зохицуулж байна вэ? | Орон нутаг дахь байгууллагын хэрэгжилтийн түвшин | Хэрэгжилтийг сайжруулахад таны оролцоо, хувь нэмэр |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

ADB Japan Fund for Poverty Reduction

From the People of Japan

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Mongolian Education Alliance

# Монгол улсын эрх зүйн баримт бичгийн тойм (Тэгш хамран сургах боловсрол)

АХБ БТ9208-МОН: Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл

Бүрэлдэхүүн хэсэг 3: Тэгш хамруулах боловсролыг дэмжих эх үүсвэр, нөөц, олон нийтийн оролцоо ба бодлого

““ ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛ

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН МОДУЛЬ”

Модуль сургалтын материал 2.3

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

## Агуулга

Боловсролын салбар



1. Эрх зүйн орчин
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын өнөөгийн байдал
3. Орон нутгийн түвшинд цаашид анхаарах асуудал

Тэмдэглэл:

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
1.Эрх зүйн орчин
Боловсролын салбар
INCLUSIVE EDUCATION
• Монгол Улсын Үндсэн хууль
• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц
• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
• Боловсролын багц хууль
• “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
• Засгийн газрын тогтоол, холбогдох бусад дүрэм журам, стандарт, тушаал заавар
• Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
1.Эрх зүйн орчин
Боловсролын салбар
Монгол Улсын үндсэн хууль
16.7. Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016.02)
Боловсролын тухай хууль (2013 онд шинэчлэн найруулсан)
Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2013 оны найруулга)
Бага, дунд боловсролын тухай хууль (2013 оны найруулга)
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017.12.19)
ХНХЯ, БСШУЯ, ЭМЯ - 3 сайдын хамтарсан тушаал (2021.12.30)

Тэмдэглэл:

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

.................................................................................................................................

